

SPEECH BY MINISTER OF FUEL AND ENERGY H.E. ERDENEBAT BADARCH AT THE SESSION ON ENERGY OF THE “INVESTOR’S FORUM – 2006”

Dear Guests, Participants,
Distinguished Ladies and Gentlemen,

First of all, as a Parliament Member, Cabinet Member and Minister of Fuel and Energy, I would like to express sincere gratitude to you for managing time to come Mongolia from all over the world with good will to cooperate with us, to invest in our country and I would like to wish pleasant stay and explore new opportunities and new projects!

Mongolia is a country with vast territory and small scattered population between Russian Federation and People’s Republic of China (PRC), and for its economic growth, poverty reduction and overall development, the development of infrastructure, such as roads, energy access and telecommunications, is vital. Due to its landlocked and remote location Mongolia is dependent on its neighbors and cross border trade, and the Government of Mongolia is keen to promote energy sector regional cooperation with its immediate neighbors and countries of the region.

From the policy view major priorities for the Government is to create necessary institutional framework for private sector participation (PSP), to meet increasing energy demand in most efficient way, to facilitative the development of renewable energy, to accelerate commercialization of energy companies and improve efficiency of energy sector.

As of the end of 2004 Mongolian economy grew at 10.6%, and power demand grew at 7%, and as of the end 2005 economy grew at the rate 6.4% and power demand grew at 4.6% and due to increased mining sector development it is expected that there will be a stable power demand increase.

Mongolia’s current total installed electricity capacity is 878.4 MW, and heat capacity is 2030 GCal/hour and the electricity transmission covers most of territory and power supplied to 19 aimag, 191 soum centers. There are 7 combined heat and power plants (CHP). From 334 soums 130 supplied from diesel stations, 6 from small hydro power plants, 2 from solar, and 3 from solar-wind hybrid systems. Soums, which use diesel stations, supplied only 3-5 hours a day because of high costs of fuel. About 0.6 per cent of total electricity is supplied from renewable energy sources, such as small hydro power plants, solar, wind systems.

The Mongolia’s power sector consists of Central energy system (CES), Eastern energy system (EES), Western energy system, local diesel generators and heat only boilers (HOB) in off grid areas, aimag and soum centers.

One third of population in Mongolia has nomadic lifestyle herding more than thirty million of livestock. Because of the nomadic style of living, it is a policy challenge to develop appropriate electricity access for them. The Government is encouraging the development of renewable energy, such as small hydro, solar and wind energy. There are ongoing projects to develop small hydro power plants (HPP), to promote the use of solar and wind energy.

In 2002 the Great Khural (Parliament) adopted the “Mongolia Integrated Power System” (MIPS) program, and the program will contribute to energy access development and will help to reduce operational expenses, to create favorable socio economic conditions for regional development, and create reliable electricity supply. The ultimate goal of “Mongolia Integrated Power System” (MIPS) program is to create a unified power grid connecting Central Energy System (CES) of Mongolia with the Western and Eastern Systems thus creating a network, which will improve the reliability and cost effectiveness. This program is consistent with other national programs, such as the Concept of Regional Development of Mongolia, Millennium Road, etc. As of today we have ongoing construction **development work** of Durgun HPP, Taishir HPP in western region and with commissioning of these plants in 2007 the western three aimags will solve the issue of power supply and will reduce the dependence in power import.

The Mongolian Parliament (State Great Hural) adopted the “National Renewable Energy Program” in 2005 aimed to promote the use and production of renewable energy in Mongolia in a sequenced and sustainable way, to reach the production of renewable energy to 3-5% from total electricity generation by 2010, and up to 20-25% by the year 2020.

The use of LPG is increasing rapidly, and the Government of Mongolia (GOM) gives an importance to the development of LPG use as a new fuel mix, as a relatively “clean” fuel compared to fossil fuel. The Government of Mongolia approved a new program “Liquefied Petroleum Gas” by its decree #184 of 2000, and it aims to promote the use of LPG by households and transport, to introduce necessary safety standards and regulations. In 2005 from neighboring countries, such as Russian Federation and China, it was imported about 2200 tons of LPG for approximately 10000 users.

In early 1990’s due to strictly controlled prices and tariffs, the power sector become unable to financially sustain by itself which led to utilization of significant amounts of loans and assistance in energy sector. As of today the power sector utilized 19% of total sovereign guaranteed loans. The bulk of loans and aid received by the government are spent for renovation and rehabilitation of combined heat and power (CHP) power plants and coal mines, which improved reliability of energy supply and there is a trend for stable growth in demand.

In 2001 the Great Khural of Mongolia (Parliament) adopted a new Energy Law, which become a legal base for restructuring in energy sector. According to Energy law, the Energy Regulatory Authority (ERA), an independent regulatory body was established, which was an important step towards creating an institutional framework for cost efficient operators for power generation, transmission, distribution and supply to enter the energy market, for introducing competitive environment.

From Ministry of Fuel and Energy, the main policy priorities and guidelines are as follow:

1. In order to meet an ultimate objective of meeting increasing demand of power in reliable, sustainable and secure way, and to meet an entire power demand by itself **it is crucial to start the development and construction of Egiin hydro power plant (HPP).**
2. It is expected that the mining sector will develop rapidly in years to come. In Southern Mongolia for development of copper deposits **at Oyutolgoi, Tsagaan Suvraga, Tavantolgoi coal reserves it is necessary to develop infrastructure, generation power plants, transmission lines** etc. We would welcome and are ready to consider proposals for cooperation from foreign investors in this area.
3. In order **to improve legal and institutional environment** for fuel and energy sector, it is necessary to amend the “Energy Law”, to promote and pass the “Renewable Energy Law”, which will create favorable conditions for investors.
4. The Government of Mongolia is working **to supply herders and rural families with modern energy sources.** The Government passed a decision to wrap up an implementation of the Government program “100000 solar ger” started in 2001 and to supply all nomadic families with renewable energy sources during 2006-2008.
5. We are working **to resolve the issue of air pollution in Ulaanbaatar and other cities.** We encourage foreign investors to cooperate in this area. Taking into account the worldwide trend of environmentally friendly, sustainable development we recognize that there are opportunities for cooperation by taking advantages of mechanisms of the Kyoto Protocol.
6. In order keep our nature for future generations and avoid damages to the nature it is important **to resolve the issue of fuel supply for rural regions.** It is crucial to create necessary environment for import, distribution and use of LPG for urban and rural households, and seek possibilities to produce LPG domestically. Also it is important to explore possibilities for well pressured, suitable for transportation high thermal value briquet fuel.

7. One of main policy objectives of Ministry of Fuel and Energy is **to ensure secure operations, financial and economic viability of fuel and energy sector**. It is important to implement necessary actions to settle arrears of fuel and energy sector, to improve financial performance.
8. Ministry of Fuel and Energy pursues the policies **to create necessary environment for private sector participation (PSP)**, to improve efficiency of energy sector, to commercialize state owned enterprises and gradually privatize them. At this moment Nalaikh heat only boiler (HOB), Baganuur HOB were privatized using management contracts, Darkhan Selenge Electricity Distribution Network (DSEDN), Sharyn Gol coal mine were privatized.
9. It is an important policy challenge **to improve an overall structure of fuel and energy sector**. There are some inconsistencies with regard of ownership of state owned companies, licensing of mineral resources, and because several government agencies are responsible for different aspects, it makes difficult to pursue comprehensive and consistent policies in fuel and energy sector. That's why it is important to improve the structure of policy formulation, development, implementation, and monitoring.
10. **Mongolia offers good potentials and is keen to promote the regional energy cooperation**. Mongolia has significant resources of coal, and it is rich with primary renewable energy sources, such as solar, wind, hydro, geothermal, and it is endowed with oil and mineral resources. Because of rapid economic growth of People's Republic of China and sky rocketing demand increase, and rich natural resources' endowment primary energy resources, such as natural gas, oil, hydro, of East Siberia of Russian Federation, there are good potentials for cooperation in developing and delivering these resources through Mongolia by pipelines, power links etc.

I introduced to you main policy priorities and guidelines we face at the Ministry of Fuel and Energy of Mongolia. Representatives of Energy Research & Development Center (ERDC), and the National Renewable Energy Center (NREC) will introduce projects in which we seek financing and cooperation. I hope that you will learn more about projects on fuel and energy, and we hope to cooperate with you in near future.

I wish you pleasant participation at the activities of the "Investor's Forum – 2006"!

Thank you for your attention!

“ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ”-ЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАР ХУРАЛДААНД ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД
Б.ЭРДЭНЭБАТЫН ХЭЛЭХ ҮГ

Эрхэм хүндэт зочид, төлөөлөгчид өө,
Эрхэм хүндэт ноёд хатагтай нараа,

Юуны өмнө цаг заваа гарган дэлхийн өнцөг булан бүрээс Монгол Улсыг зорин ирж, манай оронтой хамтран ажиллах, хөрөнгө оруулалт хийх сайхан сэтгэл өвөрлөн ирсэн Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Түлш, эрчим хүчний сайдын хувьд талархал илэрхийлж, манай сайхан оронд саатан тухлаж, шинэ боломжийг нээн шинэ төсөл хэрэгжүүлж хамтран ажиллахыг уриалъя.

Монгол улс нь өргөн уудам газар нутагтай, таруу суурьшсан хүн амтай, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай хиллэдэг бөгөөд Монгол улсын эдийн засгийн өсөлтийг хангах, ядуурлыг бууруулах, улс орны хөгжлийг хангахад дэд бүтцийн, тэр дундаа эрчим хүч, зам, харилцаа холбооны хөгжил онцгой ач холбогдолтой билээ. Далайд гарцгүй, алслагдсан газар зүйн байршилтай Монгол улсын хувьд хөрш зэргэлдээ орнууд болон бүс нутгийн орнуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх нь нэн чухал байдаг.

Монгол Улсын Засгийн газар нь түлш, эрчим хүчний салбарт хувийн хөрөнгө оруулалтыг татан оруулахад шаардлагатай эрх зүйн орчинг боловсронгуй болгох, эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэглээг хамгийн үр ашигтайгаар хангах, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн ашиглалтыг хөхүүлэн дэмжих, эрчим хүчний компаниудыг арилжааны хэлбэрт оруулж үр ашгийг нь дээшлүүлэхээр ажиллаж байна.

Монгол улсын эдийн засаг 2004 онд 10.6% хувиар өсч, эрчим хүчний хэрэглээ 7%-аар, 2005 онд эдийн засгийн өсөлт 6,4%, эрчим хүчний хэрэглээ 4,6% хувиар тус тус өссөн бөгөөд цаашид уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлттэй уялдан эрчим хүчний хэрэглээ тогтвортой өсөх хандлагатай байна.

Монгол Улсын эрчим хүчний үйлдвэрлэлийн цахилгааны суурилагдсан хүчин чадал нь 878.4 МВт, 2030 Гкал/цагт хүрч улсын нийт нутаг дэвсгэрийн ихэнхийг цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн шугам сүлжээгээр холбосон бөгөөд төвлөрсөн цахилгаан хангамжаас 19 аймаг 191 сумын ард иргэд цахилгаан эрчим хүчээр 24 цагийн турш тасралтгүй хангагдаж байна. Монгол Улсын төвийн болон бусад хэсэгт нийт 7 дулааны цахилгаан станц ажиллаж байна. Манай улсын 334 сумаас 130 гаруй нь дизель станцаас, 6 нь усан цахилгаан станцаас, 2 нь салхин станцаас, 2 нь нарны станцаас, 3 нь нар салхи хосолсон станцаас хангагддаг. Сумдын дизель станцууд нь түлшний үнээс шалтгаалж өдөрт 3-5 цаг ажиллаж байна. Нийт үйлдвэрлэж байгаа цахилгааны 0,6 хувийг усан цахилгаан станц, нар, салхины бага оврын цахилгаан үүсгүүр зэрэг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс хангаж байна.

Монгол Улсын эрчим хүчний салбар нь Төвийн эрчим хүчний систем, Зүүн бүсийн эрчим хүчний систем, Баруун бүсийн эрчим хүчний систем болон төвлөрсөн эрчим хүчний системд холбогдоогүй аймаг, сумын төв, суурин газруудын дизелийн цахилгаан станц, халаалтын зуух, дулааны цахилгаан станцуудаас бүрдэж байна.

Монгол Улс нь гуч гаруй сая малтай бөгөөд хүн амын гуравны нэг нь нүүдлийн мал аж ахуй эрхэлж байна. Хөдөөгийн малчдад тохирсон эрчим хүчний хангамжийн асуудал шийдвэрлэх нь бодлогын чухал асуудал юм. Засгийн газраас бага оврын усан цахилгаан станц, нар, салхины станц зэрэг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах явдлыг хөхүүлэн дэмжиж байгаа бөгөөд энэ чиглэлийн олон төсөл, хөтөлбөр хэрэгжиж байна.

Монгол Улсын Их Хурал 2002 онд “Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем” хөтөлбөрийг баталсан хөтөлбөрийн зорилго нь Монгол Улсын Төвийн эрчим хүчний системийг Зүүн бүсийн эрчим хүчний систем, Баруун бүсийн эрчим хүчний системтэй

холбож, нэгдсэн систем бий болгох бөгөөд ингэснээр эрчим хүчний нэгдсэн системийн найдвартай ажиллагааг хангах, үр ашгийг дээшлүүлэх боломж бүрдэх юм. Энэ хөтөлбөр нь Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Мянганы зам хөтөлбөр зэрэг бүс нутгийг хөгжүүлэх бодлогын хөтөлбөрүүдийн үзэл санаа, зарчимтай нягт уялдаатай хийгдсэн болно. Өнөөдрийн байдлаар хөтөлбөрийн хүрээнд Баруун бүсэд Дөргөн, Тайширын УЦС барьж байгуулах **бүтээн байгуулалтын** ажил ид явагдаж байгаа бөгөөд 2007 онд ашиглалтад оруулснаар баруун бүсийн гурван аймгийн цахилгаан хангамжийн асуудал шийдэгдэж, импортын цахилгааны хараат байдлаас гарах болно.

Монгол Улсын Их Хурлаас 2005 онд “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр”-ийг батлан гаргасан бөгөөд уг хөтөлбөрт Монгол улс эрчим хүчний үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилтыг шат дараатай хэрэгжүүлж, 2010 оны түвшинд улсын эрчим хүчний нийт үйлдвэрлэлийн 3-5 хувь, 2020 оны түвшинд 20-25 хувийг сэргээгдэх эрчим хүчийг ашиглан үйлдвэрлэх томоохон зорилтыг дэвшүүлсэн болно.

Шингэрүүлсэн шатдаг хий (ШШХ)-н хэрэглээ хурдацтайгаар өсөн нэмэгдэж байгаа бөгөөд Засгийн газраас энэ харьцангуй “цэвэр”, шинэ эрчим хүчний эх үүсвэрийг ашиглалт, шаардлагатай хийн сүлжээг бий болгохоор ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 184 дүгээр тогтоолоор “Шингэрүүлсэн шатдаг хий” хөтөлбөрийг баталсан нь шингэрүүлсэн шатдаг хийн хэрэглээг хөхүүлэн дэмжихэд чухал ач холбогдолтой болсон. ОХУ болон Хятад улсаас ойролцоогоор 2005 онд 2200 орчим тн хий импортлон борлуулж, нийт 10000 орчим хэрэглэгчдэд үйлчилж байна.

1990-ээд оны эхээр цахилгаан, дулааны үнийг олон жилийн туршид хатуу барьсны улмаас эрчим хүчний салбар нь санхүүгийн хувьд бие даан ажиллах боломжгүй болж улмаар гадаадын зээл, тусламжийг их хэмжээгээр авсан бөгөөд өнөөдрийн байдлаар гадаадаас Засгийн газрын баталгаатай нийт зээлийн 19% эрчим хүчний салбар авч хэрэглэсэн байна. Гадаадаас авсан зээл, тусламжийн дийлэнх хэсэг нь дулааны цахилгаан станц, нүүрсний уурхайнуудыг шинэчлэх, түлш, эрчим хүчний салбарын найдвартай ажиллагааг хангахад чухал ач холбогдолтой байсан бөгөөд үүний үр дүнд цахилгаан, дулааны хэрэглээний тогтвортой өсөлт ажиглагдаж байна.

Монгол улсын Их Хурлаас эрчим хүчний салбарт бүтцийн өөрчлөлтийг хийж, тус салбарыг зах зээлийн харилцаанд шилжүүлэх зорилгоор “Эрчим хүчний тухай” хуулийг 2001 онд батлан гаргаж, эрчим хүчний салбарт бие даасан, хараат бус зохицуулалтын механизмыг бий болгож, Эрчим хүчний зохицуулах газар (ЭХЗГ)-ыг цоо шинээр үүсгэн байгуулсан нь тус салбарт гадаад, дотоодын аж ахуйн нэгжүүд хөрөнгө оруулалт хийж, үйл ажиллагаа явуулах боломжтой болж, хамгийн хямд үнэ, тарифаар хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах, өрсөлдөөнийг бий болгох, үр ашгийг дээшлүүлэх эрх зүйн орчинг бий болгосон.

Монгол Улсын Түлш, эрчим хүчний яамнаас дараахь бодлого, чиглэлийг барьж ажиллаж байна, үүнд:

11. Улс орны өсөн нэмэгдэж байгаа **түлш, эрчим хүчний хэрэгцээг найдвартай, тогтвортой, аюулгүй хангах нь бидний эрхэм зорилго** бөгөөд Монгол Улсын эрчим хүчний хэрэгцээг бие дааж хангахын тулд Эгийн голын УЦС-ын барьж байгуулах ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна.
12. Монгол Улсын уул уурхайн салбар ойрын ирээдүйд огцом өсөх ханндлагатай байна. **Монгол Улсын өмнөд хэсэгт Оюутолгой, Цагаан суваргын зэс, Таван толгойн нүүрсний орд ашиглахад шаардлагатай дэд бүтцийг байгуулах, эрчим хүчний эх үүсвэр, цахилгаан дамжуулах агаарын шугамыг барьж байгуулахад гадаадын хөрөнгө**

оруулагчдаас санал ирүүлбэл бид судлан үзэж хамтран ажиллахад бэлэн байна.

13. **Түлш, эрчим хүчний салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох** зорилгоор “Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”, “Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль”-ийн төслийг батлуулснаар хөрөнгө оруулагчдад таатай нөхцөл бүрдэх болно.
14. Монгол Улсын Засгийн газраас **малчин болон хөдөөгийн жижиг хэрэглэгчдийг эрчим хүчээр хангах** чиглэлээр дорвитой ахиц гаргахаар ажиллаж байна. 2001 оноос хэрэгжүүлж эхэлсэн “100000 нарны гэр” хөтөлбөрийг үргэлжлүүлж, 2006-2008 онд багтаан малчин бүх өрхийг нарны цахилгаан үүсгүүрээр хангах шийдвэрийг Засгийн газар гаргаад байна.
15. Нийслэл **Улаанбаатар болон томоохон бусад хотын агаарын бохирдлыг бууруулахад** түлш, эрчим хүчний салбар дорвитой хувь нэмэр оруулах ёстой. Энэ чиглэлээр гадаадын хөрөнгө оруулагчдыг хамтран ажиллахыг уриалж байна. Дэлхий нийтээрээ байгаль орчинд сөрөг нөлөөгүй, тогтвортой хөгжлийн чиг хандлага болж байгаа бөгөөд Киотогийн протоколын механизмуудыг ашиглан хамтран ажиллах ихээхэн боломж байна.
16. **Хөдөөгийн айл өрхийг түлшээр хангах асуудал** нь төр, засгийн яаралтай шийдвэрлэхгүй бол Монгол орны байгаль орчинд нөхөж баршгүй хохирол учрах босгон дээр ирээд байна. Шингэрүүлсэн шатдаг хийг хөдөөгийн малчдын хэрэгцээнд ашиглах, шингэрүүлсэн шатдаг хийг импортлох, түгээх, хэрэглэх эрх зүйн орчинг бий болгох, мөн цаашид дотооддоо үйлдвэрлэх боломжийг судалж байна. Тээвэр даах, нягтшил, илчлэг сайтай шахмал түлш үйлдвэрлэх боломжийг судлах хэрэгтэй байна.
17. **Түлш, эрчим хүчний салбарын аюулгүй ажиллагаа, санхүү, хөрөнгийн чадавхийг сайжруулах** явдал яамны чухал бодлого, хойшлуулшгүй зорилт болоод байна. Түлш, эрчим хүчний салбарын өр, авлагын сүлжээг тайлах, санхүүгийн чадавхийг дээшлүүлэх тодорхой алхмуудыг хийгээд байна.
18. **Түлш, эрчим хүчний яамнаас эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчинг бүрдүүлэх, тус салбарын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, тус салбарын төрийн өмчит хувьцаат компаниудыг арилжааны хэлбэрт шилжүүлж улмаар шат дараатай хувьчлахад** ач холбогдол өгч ажиллаж байна. “Налайхын дулааны станц” ХК, “Багануурын дулааны станц” ХК-ийг менежментийн гэрээгээр, “Дархан-Сэлэнгэ цахилгаан түгээх сүлжээ” ХК, “Шарын гол” ХК-уудыг хувьчлаад байна.
19. **Түлш, эрчим хүчний салбарын тогтолцоог боловсронгуй болгох** нь цаг алдалгүй шийдвэрлэх асуудлын нэг болоод байна. Түлш, эрчим хүчний компаниудын өмчлөл, ашигт малтмалын лиценз олголт зэрэг нь хэд хэдэн төрийн байгууллагуудын эрх мэдэлд байгаа нь түлш, эрчим хүчний салбарт цэгцтэй, цогц бодлого явуулахад хүндрэл учруулж байгаа бөгөөд түлш, эрчим хүчний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх,

хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг боловсронгуй болгохоор ажиллаж байна.

20. Монгол Улс нь **бүс нутгийн эрчим хүчний хамтын ажиллагааг өргөжүүлэх**ээр идэвхитэй ажиллаж байна. Монгол улс нь нүүрсний нөөц ихтэй, нар, салхи, ус, газрын гүний дулаан зэрэг сэргээгдэх эрчим хүчний анхдагч эх үүсвэр сайтай, газрын тос болон эрдэс баялаг арвинтай орон билээ. БНХАУ-ын өндөр хурдацтай эдийн засгийн өсөлтөөс эрчим хүчний хэрэглээ огцом өсч байгаа бөгөөд ОХУ-ын Зүүн Сибирийн эрчим хүчний арвин их нөөц, байгалийн хий, газрын тос, цахилгаан эрчим хүчийг Монгол Улсаар дамжуулан БНХАУ-д экспортлоход хамтран ажиллах өргөн боломж байна.

Монгол Улсын Түлш, эрчим хүчний яамны үйл ажиллагааны чиглэлийг Та бүхэнд танилцууллаа. Манай яамны харьяа Эрчим хүчний судалгаа, хөгжлийн төв, Сэргээгдэх эрчим хүчний төвөөс тодорхой төслүүдийг танилцуулах болно. Та бүхнийг бидний санал болгож буй төслүүдийг судлан үзэж хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Та бүхнийг “Гадаад хөрөнгө оруулалтын чуулга уулзалт”-ын үйл ажиллагаанд тавтай сайхан оролцохыг хүсье!

Анхаарал тавьсанд баярлалаа!